



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/429 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Континентал эйр” ХХК-тай байгуулсан “Иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хороодоос үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл” нийлүүлэх тендерийн Багц-2: Хурууны хээ уншигч /24ш/, дижитал зургийн аппарат /24ш/, гарын үсгийн дүрс уншигч /24ш/, зураг авах арын дэлгэц /24ш/, зургийн аппаратын зориулалтын хөл /24ш/ НХААГ-19/050/1-2 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг /С.Ариунжаргал/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 14 өдрийн А/40 тоот тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	С.Ариунжаргал	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч
Гишүүд:	Б.Эрдэнэмөнх	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
	Г.Амарсанаа	Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын мэдээлэл, технологи хариуцсан инженер /зөвшилцсөнөөр/
	Б.Эрдэнэчимэг	Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын Захиргааны хэлтсийн ахлах мэргэжилтэн бөгөөд ерөнхий нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнгөнхүү	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн